

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ:
ШИМЛЭГ АГРО ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Н.МӨНХЖИН

УЛААНБААТАР ХОТ
БАТЛАВ:
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
М.МӨНХӨӨ

ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭ

2023 оны 11-р сарын 18-ны өдөр

№ 2023/102

Улаанбаатар хот

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээг нэг талаас “Амгалан дулааны станц ТӨХК” (цаашид “Түрээслэгч” тал гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, “Трипле эвент холл” (цаашид “Түрээслүүлэгч” гэх) түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал Н.Мөнхжин нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.
- 1.2 Энэхүү гэрээгээр Түрээслэгч нь чанар стандартын шаардлага хангасан ширээ, сандал, тайз, техник, тоног төхөөрөмж, хэрэгсэл, танхим түрээсийн үйлчилгээ (цаашид “танхим түрээслэх” гэх)-г үзүүлэх ба зууш, ундаа, усаар үйлчилнэ.

ХОЁР. ТАНХИМ ТҮРЭЭСЛЭХ ХУГАЦАА, ҮНЭ, ТӨЛБӨР ТООЦОО

- 2.1 Түрээслүүлэгч нь хурлын танхимыг 2023 оны 12-р сарын 28-ний өдрийн 17:00 цагаас эхэлж, мөн өдрийн 22:00 цаг хүртэлх хугацаанд түрээслүүлнэ.
- 2.2 Түрээслэгч нь төлбөр тооцоог доорх хуваарийн дагуу төлөх бөгөөд урьдчилгаа төлбөр төлөгдсөнөөр гэрээг баталгаажсанд тооцно.

Төлбөр	Хувь	Дүн	Төлбөр төлөх огноо
Урьдчилгаа төлбөр	68,7	11000000	2023.XI/17-20
Үлдэгдэл төлбөр	31,3	5000000	2023.XII/25

Төлбөрийг Түрээслэгчийн “Шимлэг агро” ХХК-ийн ХХБ-ны 435013951 тоот дансанд шилжүүлнэ.

ГУРАВ. ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Түрээслүүлэгч нь түрээслэгч талд эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага, стандартын шаардлагыг тус тус хангасан үйлчилгээг үзүүлнэ.
- 3.2 Түрээслүүлэгч нь арга хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмж, мэргэжлийн зөөгч, тэгсоч, техникч, зэрэг боловсон хүчнээр соёлч боловсон түргэн шуурхай үйлчилгээг үзүүлнэ.
- 3.3 Гэрээнд заасан хугацааны дагуу үйлчилгээ үзүүлсэний төлбөрийг нэхэмжлэх, шаардах эрхтэй.
- 3.4 Ажилтнуудад гэрээгээр тохирсоноос бусад үйлчилгээ, бараа, бүтээгдэхүүнийг хямдралтай үнээр түргэн шуурхай үйлчилнэ.

ДӨРӨВ. ТҮРЭЭСЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1 Түрээслэгч нь захиалга өгөхдөө оролцох хүний тоо, зууш, ус, ундаатай цэс, хэрэглэгдэх тоног төхөөрөмжийг маш тодорхой, нарийн тохиролцож баталгаажуулан гарын үсэг зурна. Гэрээнд өөрчлөлт орсон тохиолдолд арга хэмжээ болохоос 3 хоногийн өмнө эцсийн байдлаар түрээслүүлэгч талд мэдэгдэж баталгаажуулна.

- 4.2 Төлбөрийг гэрээнд заасан хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.3 Түрээслэгч нь арга хэмжээнд бараа бүтээгдэхүүн /чихэр, жимс, самар г.м./ гаднаас оруулсан тохиолдолд шинжилгээ хийлгэсэн байх ба тухайн бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн шаардлага хангасан байна. Үүнээс үүдэн гарсан аливаа эрсдэлийг түрээслэгч тал бүрэн хариуцна.
- 4.4 Түрээслэгч нь арга хэмжээг гэрээнд заасан хугацаандаа эхэлж, хугацаандаа дуусгах үүрэгтэй. Нэмэлт цаг сунгасан тохиолдолд заалны түрээсийн төлбөрт цаг тутам нэмэлт төлбөр төлнө.
- 4.5 Түрээслүүлэгч нь үйлчилгээний танхимд түрээслэгчийн хувцас, цүнх болон бусад эд зүйлсийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж хариуцна.
- 4.6 Арга хэмжээний үеэр эрүүгийн шинж чанартай үйлдэл, нийтийг хамарсан эмх замбараагүй асуудал гаргахгүй байхыг түрээслэгч тал бүрэн хариуцах бөгөөд уг нөхцөл байдлаас үүсэн гарах аливаа эрсдэлийг бүрэн хариуцна.
- 4.7 Түрээслэгч нь гэрээнд заасан цагтаа соёлтой боловсон үйлчлүүлэх ба хэрвээ эд хогшил, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд гэмтэл учруулсан тохиолдолд хохирлыг түрээслүүлэгч талын зохих тарифаар хохирлыг бүрэн барагдуулна.
- 4.8 Түрээслэгч нь түрээслүүлэгчид өгсөн захиалгын дагуу бүх үйлчилгээг чанартай гүйцэтгэхийг шаардах эрхтэй бөгөөд өөрийн талаас нэг төлөөлөгч томилж хяналт тавина.

ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1 Талууд хариуцсан үүргээ биелүүлээгүйгээс шалтгаалан нөгөө талд хохирол учруулбал буруутай тал бүрэн хариуцаж, хохиролыг барагдуулна.
- 5.2 Үйлчилгээний зааланд түрээслэгчийн зочин, үйлчлүүлэгч нар өөрсдийн үнэт эдлэл, зургийн аппарат, камер, цүнх болон бусад эд зүйлийг өөрсдөө бүрэн хариуцах бөгөөд алдаж үрэгдүүлсэн тохиолдолд түрээслүүлэгч хариуцлага хүлээхгүй, энэхүү асуудлыг зохицуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 5.3 Түрээслэгч тал энэхүү гэрээг гэрээ баталгаажсан өдрөөс хойш 3 хоногийн дотор цуцалсан тохиолдолд торгууль тооцохгүй, урьдчилгаа төлбөрийг бүрэн олгоно. Харин арга хэмжээ болох өдрөөс 21-с дээш хоногийн өмнө цуцалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрөөс 50 хувийг, 21-с дотогш хоног дотор цуцалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийг олгохгүй болно. /Гөрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр түрээслэгч тал арга хэмжээ зохион байгуулах боломжгүй болсон нөхцөлд уг заалт хамаарахгүй бөгөөд түрээслүүлэгч тал урьдчилгаа төлбөрийг 100 хувь буцаан олгоно./
- 5.4 Түрээслүүлэгч нь арга хэмжээ болох өдрөөс 21-ээс дээш хоногийн өмнө цуцлагдсан тохиолдолд урьдчилгаа төлбөрөөс 50 хувиар, 21-ээс дотогш хоног дотор цуцалсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийн 100 хувиар алданги хүлээнэ. Цуцлагдсан өдрөө урьдчилгаа төлбөр болон алдангийг төлнө.
- 5.5 Түрээслэгч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөр зохих үнийн дүнгийн 0.3 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг түрээслүүлэгчид төлнө.
- 5.6 Учирсан хохирол гэдэгт талууд гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан нэмэлт зардал, илүү төлбөр, гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлсэн бол гарахгүй байсан зардал, гэх мэт хохирлыг тооцно.

ЗУРГАА. БУСАД

- 6.1 Хууль тогтоомжид заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.
- 6.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн эсэргүүцлийн хөдөлгөөн, терийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээр зэрэг талуудаас үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

- 6.3 Дэлхий нийтийг хамраад буй Ковид-19 цар тахлын улмаас хорио цээрийн дэглэмийг төр засгийн зүгээс чангатгаж арга хэмжээг хийх боломжгүй болсон тохиолдолд Түрээслүүлэгч тал нь урьдчилгаа төлбөрийг буцаан олгохгүй бөгөөд уг хорио цээрийн дэглэм дуусгавар болсоны дараа Түрээслэгч талтай тохиролцож зөвхөн үйлчилгээг үзүүлнэ.
- 6.4 Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх үүргээ аль нэг талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэх эрхгүй.
- 6.5 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

БАТАЛГААЖУУЛАЛТ



ТҮРЭЭСЛҮҮЛЭГЧ:
“ШИМЛЭГ АГРО” ХХК
РД: 6138861

МЕНЕЖЕР: / [Signature] /
ГАРЫН ҮСЭГ

ХАЯГ: ХАН-УУЛ ДҮҮРЭГ-15-Р ХОРОО, "ИХ
НАЯД ПЛАЗА" ТӨВ, 6 ДАВХАР. "ТРИПЛЕ"
ЭВЕНТ ХОЛЛ

УТАС: 90793333, 90783333, 88058307

ТҮРЭЭСЛЭГЧ :
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК
РД: 6021646

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ
НЯГТЛАН БОДОГЧ

[Signature] Ө.УДВАЛ

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

[Signature] Б.ГАН-ОЧИР

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

[Signature] Г.БАТТУЛГА

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

Г.САРУУЛ

[Signature]